



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

Журам, загвар батлах, үнэ  
тогтоох тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам"-ыг нэгдүгээр, "Монгол Улсын жолоочийн үнэмлэхний загвар"-ыг хоёрдугаар, "Монгол Улсын Олон улсын жолоочийн үнэмлэхний загвар"-ыг гуравдугаар, "Жолоочийн түр зөвшөөрлийн загвар"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын "Жолоочийн үнэмлэх"-ний үнэ 12 500 төгрөг /арван хоёр мянга таван зуун төгрөг, "Олон улсын жолоочийн үнэмлэх"-ний 20 000 төгрөг /хорин мянган төгрөг/ байхаар тогтоосугай.


3. Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2008 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө олгосон жолоодох эрхийн үнэмлэхийг солих ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Цагдаагийн ерөнхий газар /тэргүүн комиссар Р.Чингис/-т үүрэг болгосугай.

4. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /тэргүүн комиссар Р.Чингис/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Үнэнбат/ нарт тус тус даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2012 оны А/38, 2015 оны А/102 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


6. Энэ журмыг 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Д.ДОРЛИГЖАВ

Хууль зүйн сайдын 2015 оны  
08 дугаар сарын 28-ны өдрийн 11/Дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



## ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцид нийцүүлэн Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэх /цаашид "Үндэсний жолоочийн үнэмлэх" гэх/, Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх /цаашид "Олон улсын жолоочийн үнэмлэх" гэх/ олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Жолоочийн үнэмлэх олгох ажлыг нийслэлд Цагдаагийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох ажил хариуцсан нэгж, орон нутагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан замын цагдаагийн нэгж /цаашид "Цагдаагийн байгууллагын эрх бүхий нэгж" гэх/ хариуцна.

1.3. Монгол Улсын үндэсний болон олон улсын жолоочийн үнэмлэх нь Монгол улсын жолоочийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн төлөв, жолоочийн бүртгэлийн хуудсаар баталгаажна.

### Хоёр. Жолоочийн үнэмлэх олгох үйл ажиллагаа

2.1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий нэгж нь жолоочийн үнэмлэх олгохтой холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. жолоодох эрхийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн иргэнд тохирох ангиллын үндэсний жолоочийн үнэмлэх олгох;

2.1.2. жолоочийн бүртгэл, мэдээллийн санг хөтөлж, мэдээллийг ашиглах, нууцлалыг хадгалах, жолоочийн тухай лавлагаа гаргах;

2.1.3. хууль тогтоомжид заасны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, сэргээх явцад жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгох, устгах, нөхөж олгох;

2.1.4. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орнуудаас олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоочийн үнэмлэхээр солих;

2.1.5. Монгол Улсын Олон улсын жолоочийн үнэмлэх олгох;

2.1.6. жолоочийн үнэмлэхний хугацаа дууссан иргэнд үнэмлэхийг шинээр олгох.

2.2. Монгол Улсын үндэсний болон Олон улсын жолоочийн үнэмлэхийг өөрт нь, эсвэл итгэмжлэл бүхий иргэн, хуулийн этгээдэд олгож болно.

### Гурав. Үндэсний жолоочийн үнэмлэх олгох

3.1. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт өгч тэнцсэн иргэнд дараах материалыг үндэслэн үндэсний жолоочийн үнэмлэх олгоно:

3.1.1. иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол гадаад паспорт;

3.1.2. тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журамд заагдсан үнэлгээний хуудас;

3.1.3. эрүүл мэндийн тодорхойлолт;

3.1.4. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй, 1 хувь;

3.1.5. үнэмлэхний үнэ төлсөн баримт.

3.2. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журмын дагуу үндэсний жолоочийн үнэмлэхийг шалгалтгүйгээр нөхөж буюу сольж олгох тохиолдолд энэ журмын 3.1.2-т заасан үнэлгээний хуудсыг шаардахгүй.

3.3. Тодорхой шалтгааны улмаас /үнэмлэх хэвлэх үйл ажиллагаа тасалдсан, зогссон гэх мэт/ үндэсний жолоочийн үнэмлэхийг хэвлэж олгох боломжгүй үед энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн түр зөвшөөрөл /цаашид "түр зөвшөөрөл" гэх/-ийг 3 сар хүртэл хугацаатай олгож болно.

3.4. Түр зөвшөөрөл олгосон жолоочид үндэсний жолоочийн үнэмлэхийг хэвлэж олгохдоо энэ журмын 3.1-д заасан материал бүрдүүлэхийг шаардахгүй.

3.5. Түр зөвшөөрөл нь үндэсний жолоочийн үнэмлэхтэй нэгэн адил хүчинтэй байх бөгөөд жолоочийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэж баталгаажсан байна.

3.6. Үндэсний жолоочийн үнэмлэх хэвлэж, олгосон тохиолдолд түр зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.

3.7. Монгол Улсын иргэн болон Монгол Улсад 1 жилээс дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэн Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхээ Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэхээр солиулах хүсэлт гаргасан тохиолдолд тохирох ангиллын үнэмлэхээр шууд сольж олгоно.

3.8. Энэ журмын 3.7 дахь хэсэгт заасан үндэслэлээр Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэхийг сольж олгох явцад ангиллын зөрүү гарвал Цагдаагийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох ажлыг хариуцсан нэгжийн дарга шийдвэрлэнэ.

3.9. Монгол Улсад суугаа Элчин сайдын яам болон Консулын газрын дипломат төлөөлөгчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хүсэлтийг үндэслэн түүнд жолоочийн үнэмлэхтэй нь тохирох ангиллын үндэсний жолоочийн үнэмлэхийг шууд олгож болно.

3.10. Энэ журмын 3.7 дахь хэсэгт заасан шалгуурыг хангаагүй жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоочийн үнэмлэхээр сольж олгохгүй.

3.11. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн бус орноос олгосон жолоодох эрхийн үнэмлэхтэй гадаадын болон Монгол Улсын иргэн энэхүү журмын 3.1-т заасан материалыг бүрдүүлж жолоочийн үнэмлэх авна.

### **Дөрөв. Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэх олгох**

4.1. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэх бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн хүсэлт гаргасан тохиолдолд олон улсын жолоочийн үнэмлэх олгож болно.

4.2. Олон улсын жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан Монгол улсын иргэнд дараах бичиг баримтыг үндэслэн олгоно:

4.2.1. хүсэлт;

- 4.2.2. жолоочийн бүртгэлийн хуудас;
- 4.2.3. иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эсхүл иргэний үнэмлэхний цахим лавлагаа;
- 4.2.4. үндэсний жолоочийн үнэмлэх, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 4.2.5. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй, 2 хувь;
- 4.2.6. олон улсын жолоочийн үнэмлэхний үнэ төлсөн баримт.

4.3. Олон улсын жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан гадаадын иргэнд дараах бичиг баримтыг үндэслэн олгоно:

- 4.3.1. хүсэлт /монгол хэл дээр/;
- 4.3.2. жолоочийн бүртгэлийн хуудас;
- 4.3.3. гадаад паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 4.3.4. Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн гишүүн орноос олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоочийн үнэмлэх түүний монгол хэл дээр хөрвүүлсэн албан ёсны орчуулга, эсхүл Монгол Улсын үндэсний жолоочийн үнэмлэх, тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 4.3.5. өнгөт цээж зураг 3x4 хэмжээтэй-1 хувь, 4x6 хэмжээтэй -1 хувь;
- 4.3.6. олон улсын жолоочийн үнэмлэхний үнэ төлсөн баримт.

### Тав.Бусад

5.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.3 дахь хэсэгт заасан жолоочийн бүртгэл, мэдээллийн санд жолоочийн үнэмлэх шинээр болон нөхөн олгосон, ангилал нэмсэн, эрх хассан болон сэргээсэн, зөрчлийн оноо, олон улсын жолоочийн үнэмлэх, түр зөвшөөрөл олгосон мэдээллийг оруулна.

5.2. Жолоочийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг Цагдаагийн байгууллага хариуцна.

5.3. Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан, бэлэн бус торгуулийн болон шаардлагатай бусад мэдээллийг нэгтгэсэн, тэдгээртэй уялдан ажиллах чадвартай байна.

5.4. Жолоочийн үнэмлэхийг хүлээлгэн өгсөн, устгасан тухай тэмдэглэл үйлдэж, оролцогчид гарын үсэг зурсан байна.

5.5. Жолоочийн үнэмлэхийг олгосон болон эрх сэргээсэн тухай гар бичмэл, үнэлгээний хуудас, холбогдох материалыг Үндэсний архивын газрын даргын баталсан "Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт"-ын дагуу хадгална.

5.6. Энэхүү журмыг зөрчсөн Цагдаагийн алба хаагч болон иргэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 2-ны өдрийн 81129 дугаар туцаалын хоёрдугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЭХ ЗАГВАР, НУУЦЛАЛ

## А. Нүүрэн тал

**ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ**  
Mongolian driver's license



Урьдын овог / Family name:  
**ӨӨЛД**  
UID:  
Эцэг / Father's name:  
**НАМСРАЙ**  
**НАМБРАЛ**  
Нэр / Given name:  
**ПҮРЭВДОРЖ**  
PUREVDORJ  
Тусламжийн дугаар / Card number:  
M 866997  
Тусламжийн дугаар / Card number:  
\* B C D \* \*  
Цусны бүлэг / Blood type:  
O (II)  
Гарын үсэг / Signature:  
ХЛ 83010759  
1983-01-07  
Ауяар / Sex:  
Эр / m

## Б. Ар тал


**MGL PERMIS DE CONDUIRE**

Тээврийн хэрэгслийн ангилал:  
Vehicles of category:


Ангилал / Category	Огноосон өдөр / Issued
A	*
B	2009-09-28
C	2010-12-02
D	2011-10-17
E	*
M	*

Огноосон өдөр / Issued:  
2011-10-17  
Хувирах өдөр / Expires:  
2021-10-17  
Тусгай тэмдэглэл / Special note:  
Даргачин байгууллага / Issuing authority:  
Нийслэлийн Ерөнхий Газар  
National Police Agency of Mongolia  
Card number:


## В. Хэт яагаан туяаны нууцлал



## Г. Голограммын нууцлал



## Д. Бүтэц, зохион байгуулалт



## **Монгол Улсын жолоочийн үнэмлэхний загвар, нууцлалын тухай мэдээлэл**

Тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэхний мэдээлэл нь цахим байдлаар агуулагдах олон улсын "CR80" стандарт, чанарын шаардлага хангасан смарт картаар хийгдэнэ.

Жолоочийн үнэмлэхний дэвсгэр өнгө нь тэнгэрийн цэнхэр бөгөөд төвөөс цацарсан хэлбэртэй усан хээтэй байна. Нүүрэн талын дээд, ар талын дээд болон зүүн хажууд "Жолоочийн үнэмлэх" гэж Монгол, Франц, Англи хэлээр, нүүрэн талын баруун хажууд Уйгаржин үсгээр бичнэ.

Жолоочийн үнэмлэх дээр хэвлэгдэх мэдээлэл:

1. Нүүрэн талд жолоочийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн болон үнэмлэхний дугаар, жолоодох эрхийн ангилал, төрсөн огноо, цусны бүлэг, хүйс, жолоочийн өнгөт зураг, гарын үсэг зэрэг мэдээллийг англи, монгол хэл дээр хэвлэсэн байна.
2. Ар талд тухайн жолоочид олгосон жолоодох эрхийн тээврийн хэрэгслийн ангилал, үнэмлэхийг хэвлэж олгосон болон хүчинтэй байх хугацаа, тусгай тэмдэглэл, олгосон байгууллагын нэр болон тамга зэрэг мэдээллийг англи хэл дээр хэвлэгдсэн байна.

### **Нууцлал болон бусад мэдээлэл**

"Жолоочийн үнэмлэх"-ний баруун дээд өнцөгт Монгол Улсын "Төрийн далбаа" нүүрэн талын голд бадамлянхуа цэцгийн суурин дээр "Төрийн соёмбо", ар талд зүүн дээд болон Монгол Улсын газрын зурагны голд "MGL" гэсэн ялгах тэмгийг тус тус байрлуулсан байна.

Нүүрэн талд хэт ягаан туяаны тусгалд тодрох "Цагдаагийн байгууллагын билэгдэл"-ийг цэнхэр өнгөөр, нүүрэн талд олон улсын шаардлагад нийцсэн голограммын нууцлалтай байна.

Жолоочийн үнэмлэхний цахим чипэнд агуулагдах мэдээлэл:

1. Регистрийн дугаар;
2. Ургийн овог;
3. Эцэг /эх/-ийн нэр;
4. Нэр;
5. Төрсөн он, сар, өдөр;
6. Жолоочийн үнэмлэхний дугаар;
7. Жолоочийн үнэмлэх олгосон он, сар, өдөр;
8. Жолоочийн үнэмлэхний төлөв байдал;
9. Жолоочийн зураг;
10. Цусны бүлэг;
11. Жолоочийн цахим гарын үсэг;
12. Жолоочийн хаягийн бүртгэлийн талаарх мэдээлэл;
13. Жолоочийн зөрчлийн бүртгэл, онооны системийн бүртгэл;
14. Жолоочийн албан журмын даатгалын талаарх мэдээлэл;
15. Бэлэн бус төлбөр тооцооны бүртгэл, систем;
16. Бусад мэдээлэл



Олон улсын жолоочийн үнэмлэхний эх загвар

INTERNATIONAL DRIVERS DOCUMENT  
 LICENCIA DE CONDUCIR INTERNACIONAL  
 ВОДИТЕЛЬСКОЕ УДОСТОВЕРЕНИЕ  
 PERMIS DE CONDUIRE INTERNACIONAL  
 国际驾照 国际驾照 国际驾照



INTERNATIONAL  
 DRIVERS LICENSE

International Translated Driver's license in 8 languages were issued under an Agreement between 260 Nations on Road Traffic in 1949 & 2011

МОНГОЛ УЛС  
 MONGOLIA

Олон улсын автомашины хөдөлгөөн  
 International Motor Traffic

ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ  
 International Driving Permit


№: \_\_\_\_\_  
 /International driving permit No./

1968 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн  
 Замын хөдөлгөөний тухай Конвенц  
 Convention on International Road Traffic of 08 November 1968

Хүчинтэй хугацаа:  
 /Valid until/

Олгосон огноо:  
 /Date of Issue/

Үндэсний жолоочийн үнэмлэхний №:  
 /No. of Domestic Driving License/





Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газар  
 National Police Agency of Mongolia






- Эцэг /эх/-ийн нэр 1.  
 Нэр 2.  
 Төрсөн газар 3.  
 Төрсөн огноо 4.  
 Оршин суугаа хаяг 5.


Мотоцикл	A
"A" ангилалд заагдсанаас бусад бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй, жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай автомашин.	B
Ачаа тээвэрлэхэд зориулсан, бүх жин нь 3500 кг-аас илүү автомашин.	C
Жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин.	D
Жолоодох эрхтэйгээр олгогдсон "B", "C", "D" ангилалд хамарагдах чирэгчтэй тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн (энэ бүрэлдэхүүн нь эдгээр ангилалд дангаараа багтахгүй бол)	E

Ашиглахыг хязгаарласан нохцлоод

Хасалт	Exclusions
Эзэмшигч нь: ..... нутаг дэвсгэрт ..... хуртэл жолоодох эрхээ хасуулсан болно. Хассан байгууллагын тэмдэг: 	
Огноо: .....	

- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_

- A  Seau ou cachet de l'autorité
- B  Seau ou cachet de l'autorité
- C  Seau ou cachet de l'autorité
- D  Seau ou cachet de l'autorité
- E  Seau ou cachet de l'autorité



Эзэмшигчийн гарын үсэг

/Signature/

EXCLUSIONS  
 (pays)


- |            |             |
|------------|-------------|
| I. _____   | V. _____    |
| II. _____  | VI. _____   |
| III. _____ | VII. _____  |
| IV. _____  | VIII. _____ |



Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэх

ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХНИЙ  
ЭХ ЗАГВАР

Хуудасны загвар 1



Хуудасны загвар 2

МОНГОЛ УЛС  
MONGOLIA

Олон улсын автомашины хөдөлгөөн  
International Motor Traffic

ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ  
International Driving Permit

№: 000201512  
International driving permit No.:

1968 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн  
Замын хөдөлгөөний тухай Конвенц  
Convention on International Road Traffic of 08 November 1968

Хүчинтэй хугацаа: 2015.08.26 - 2018.08.26  
Valid until

Олгосон өгнө: 2015.08.26  
Date of Issue

Үндэсний жолоочийн №: 585967  
No. of Domestic License

Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газар  
National Police Agency of Mongolia

Хуудасны загвар 3

Энэг /хүч/ийн нэр 1.  
Нэр 2.  
Төрсөн газар 3.  
Төрсөн өгнөө 4.  
Орнин суугаа хяг 5.

ЖОЛООЧИЙН ХОЛБОГДОХ  
ТЭМДЭГЭЭЛ

Мотоцикл	A
"А" ангилалд загварлас бусад бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй, жолоочис гадна наймаас илүүгүй хүний суудалтай автомашин.	B
Ачаа тээвэртээд зориулсан, бүх жин нь 3500 кг-аас илүү автомашин.	C
Жолоочис гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэртээд зориулсан автомашин.	D
Жолоочид эрхтэйгээр өгөгдсөө "B", "C", "D" ангилалд ашиглагдах чирэгчлэ тээвэрнэй хэрэгсэлнэй бүрэлдэсгүү (инэ бүрэлдэхүүн нь эдгээр ангилалд дөнгөвөөр бичгөөгүй бол)	E

Анхиллын хэлтэвэрлэсэн нохиолууд

Хасалт	Exclusions
Зэмчилсэн нь: ..... нутаг дэвсгэрт ..... хүртэл жолоочис аргаар хасуулсан болно. Хасан байуулагчийн тэмдэг:	
Огноо: .....	

Хуудасны загвар 4

1. Namsrai  
2. Purevdorj  
3. Ulaanbaatar, Mongolia  
4. 1983.01.07  
5. Амгьтэй-26, Ахуй-1, ул.д/с, Улаанбаатар, Монгол

Энгийн чийгн гарал үзэг  
Signature

EXCLUSIONS (гүйсгэл)

I. \_\_\_\_\_ VI. \_\_\_\_\_  
II. \_\_\_\_\_ VII. \_\_\_\_\_  
III. \_\_\_\_\_ VIII. \_\_\_\_\_  
IV. \_\_\_\_\_



## **Жолоочийн түр зөвшөөрлийн тухай мэдээлэл**

Тээврийн хэрэгслийн жолоочийн түр зөвшөөрөл нь 90X60 мм хэмжээтэй чанарын шаардлага хангасан фото цаасан дээр хэвлэгдэнэ.

Жолоочийн түр зөвшөөрлийн дэвсгэр өнгө нь мөнгөлөг саарал, төвөөс цацарсан хэлбэртэй усан хээтэй байх бөгөөд нүүрэн талын дээд болон зүүн хажууд “Жолоочийн түр үнэмлэх” гэж Монгол, Уйгаржин үсгээр бичнэ.

**Жолоочийн түр зөвшөөрөл дээр хэвлэгдэх мэдээлэл**

1. Нүүрэн талд жолоочийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, регистр, үнэмлэхний дугаар, жолоодох эрхийн ангилал, төрсөн он, сар, өдөр, цусны бүлэг, хүйс, жолоочийн зураг өнгөтөөр Монгол Улсын “Жолоочийн түр зөвшөөрөл”, олгосон байгууллага, хүчинтэй хугацаа гэх мэдээллийг монгол хэл дээр хэвлэгдсэн байна.
2. Ар талд тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгосон талаарх мэдээлэл, олгогдсон ангилал, тухайн үнэмлэхийн хэвлэж олгосон огноо, хүчинтэй огноо, санамж, баркод байна.

## **Нууцлал болон бусад мэдээлэл**

“Жолоочийн түр зөвшөөрөл”-ийн баруун дээд өнцөгт Монгол Улсын “Төрийн далбаа” нүүрэн талын голд бадамлянхуа цэцгийн суурин дээр “Төрийн соёмбо”, ар талд Монгол Улсын газрын зураг “MGL” гэсэн ялгах тэмгийг тус тус байрлуулсан байна.

Нүүрэн талд “Цагдаагийн байгууллагын билэгдэл”-ийг товойлгон олон улсын шаардлага хангасан QR Code-ийг агуулсан байна.